

**БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГАД НЭР ДЭВШҮҮЛЭХ  
АСУУДЛААР ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНООС  
ГАРГАСАН САНАЛ, ДҮГНЭЛТ**

2020 оны 7 дугаар  
сарын 09-ний өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.7, 17 дугаар зүйлийн 17.3.5 дахь заалт, 26 дугаар зүйлийн 26.4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн Эдийн засгийн байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх тухай асуудлыг Байнгын хороо 2020 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцээд дараах санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулж байна.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатарын Улсын Их Хуралд сонгогдон ажилласан туршлага, төрийн ажлын мэдлэг, ур чадварыг харгалзан Эдийн засгийн байнгын хорооны даргад нэр дэвшүүлснийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Эдийн засгийн байнгын хорооны даргад Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатарыг нэр дэвшүүлсэн тухай Байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ, УЛСЫН ИХ  
ХУРЛЫН ГИШҮҮН**



**Б.БАТТӨМӨР**